



ᠰᠠᠨᠬᠡᠭᠦᠭᠢᠢᠨ
ᠵᠣᠬᠢᠴᠢᠭᠤᠯᠠᠬᠤ
ᠬᠣᠷᠤᠭ᠎ᠠ

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ 2020 ОНЫ II УЛИРАЛ

АГУУЛГА

I. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Санхүүгийн зах зээлийн төлөв

8

Хүртээмжтэй байдал

10

Бүтээгдэхүүн үйлчилгээ

12

Ашигт ажиллагаа

14

Тогтвортой байдал

16

Бодлого зохицуулалт

17

II. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Санхүүгийн зах зээлийн төлөв

20

Хүртээмжтэй байдал

24

Бүтээгдэхүүн үйлчилгээ

27

Ашигт ажиллагаа

29

Тогтвортой байдал

30

Бодлого зохицуулалт

31

III. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Санхүүгийн зах зээлийн төлөв

34

Хүртээмжтэй байдал

37

Бүтээгдэхүүн үйлчилгээ

40

Ашигт ажиллагаа

44

Тогтвортой байдал

46

Бодлого зохицуулалт

48

IV. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Санхүүгийн зах зээлийн төлөв	Хүртээмжтэй байдал	Бүтээгдэхүүн үйлчилгээ	Ашигт ажиллагаа	Тогтвортой байдал	Бодлого зохицуулалт
52	54	58	62	64	66

V. ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Санхүүгийн зах зээлийн төлөв	Хүртээмжтэй байдал	Бүтээгдэхүүн үйлчилгээ	Ашигт ажиллагаа	Тогтвортой байдал
70	71	73	74	75

VI. ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ


Салбарын төлөв	Хүртээмжтэй байдал	Бүтээгдэхүүн үйлчилгээ	Бодлого зохицуулалт
78	79	80	82

VII. ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧ

Салбарын төлөв	Хүртээмжтэй байдал	Бүтээгдэхүүн үйлчилгээ	Ашигт ажиллагаа	Бодлого зохицуулалт
86	87	88	89	91

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж	ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага	ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	ХК	Хувьцаат компани
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс	ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн	ХОМК	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан	ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас	ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү	МАРІХ	Монголын хөдөө аж ахуйн барааны үнийн индекс
ЗЗҮ	Зах зээлийн үнэлгээ	ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
МББСБХ	Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо	ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
МИК	Монголын ипотекийн корпораци	АFI	Alliance for Financial Inclusion /Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг/
МХБ	“Монголын хөрөнгийн бирж” ХК	АТМ	Automated teller machine /Автомат теллер машин/
МХЗХҮХ	Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо	IAIS	International Association of Insurance Supervisors /Олон улсын даатгалын зохицуулагчдын холбоо/
МҮЦБ	“Монголын үнэт цаасны бирж” ХК	IPO	Initial public offering /Олон нийтэд хувьцаагаа санал болгох/
ПОС	Карт уншигч төхөөрөмж	FPO	Follow up on public offering /Нэмэлт хувьцаа гаргах/
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо	OECD	The Organisation for Economic Co-operation and Development /Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага/
ТДЦА	Татварын дараах цэвэр ашиг		
ТЗК	Тусгай зориулалтын компани		
ҮХЭХЗ	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал		
ҮЦК	Үнэт цаасны компани		
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв		
ХАА	Хөдөө аж ахуй		
ХААДД	Хөдөө аж ахуйн давхар даатгал		
ХЖДХ	Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү		
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам		





ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Зах зээлийн үнэлгээ

2,503.7
тэрбум төгрөг



Санхүүгийн зах зээлийн төлөв

Дансны тоо
2,296,933



Хүртээмжтэй байдал

Нийт арилжааны дүн
29.1 тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



ҮЦК-ийн хөрөнгө

98.4

тэрбум төгрөг

Тогтвортой байдал



ТОП-20 индексийн
хэлбэлзэл

1,294.5

Бодлого зохицуулалт



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ



Үнэт цаасны зах зээлд нийт **526** зохицуулалттай этгээд, хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байна

Арилжаа эрхлэх 2	Тооцооны 2	Төвлөрсөн хадгаламж, үнэт цаасны арилжааны төлбөрийн 1
ХОМК 23	Арилжаа эрхлэгчдийн холбоо 1	Кастодиан 3
Андерайтерийн зөвшөөрөлтэй банк 2	Хөрөнгө итгэмжлэн удирдах 5	ХК 304
ҮЦК* 53	ХАА түүхий эдийн арилжаа эрхлэх 1	ХАА түүхий эдийн брокер 14
ҮЦ33-д аудитын үйлчилгээ үзүүлэх 59	ҮЦ33-д хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх 24	ҮЦ33-д хуулийн үйлчилгээ үзүүлэх 33

*ҮЦК-д брокер, дилер, андерайтер болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагыг хамаатуулна.





Үнэт цаасны зах зээлийн арилжаа

- 2020 оны 2 дугаар улиралд нийт 29.1 тэрбум төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжаалагдсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 67.8 хувиар буурсан.
- Нийт арилжааны 2 хувийг ЗГУЦ, 17.2 хувийг компанийн бонд, 80.8 хувийг хувьцаа тус тус эзэлж байна

Зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадвар

- Нийт зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.9 хувиар буурч 2.5 их наяд төгрөгт хүрсэн бол хөрвөх чадвар 2.4 пунктээр буурч 0.9 хувьд хүрлээ.






Үнэт цаасны зах зээлийн индекс

- ТОП-20 Индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,576.3 нэгжээр буюу 22.0 хувиар буурсан.
- MSE А индекс өмнөх оны мөн үеэс 1,680.6 нэгжээр буюу 17.2 хувиар буурсан.
- MSE Б индекс өмнөх оны мөн үеэс 635.9 нэгжээр буюу 7.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




ХААБ-ээр нийт 162.1 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 361 тэрбум төгрөгөөр буюу 69.0 хувиар буурсан үзүүлэлт бөгөөд зөвхөн 4 төрлийн бүтээгдэхүүн арилжигджээ.



ХАА-н биржийн МАРИХ индекс

ХААБ-ээс тооцон гаргадаг Монголын хөдөө аж ахуйн индекс буюу МАРИХ 2020 оны 2 дугаар улирлын байдлаар 918,691.4 нэгжид хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 54,687.0 нэгжээр өссөн.




ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ТОП-20 ИНДЕКСТ БАГТАХ ХК-УУДЫН САЛБАРЫН АНГИЛАЛ



ХУВЬЦААНЫ ТӨВЛӨРӨЛ

- Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 10 ХК-ийн төвлөрлийг тооцож үзэхэд хэт төвлөрөлтэй буюу нийт хувьцааны 90.9 хувийг нийт хувьцаа эзэмшигчдийн 0.1 хувь нь эзэмшиж байна.



5-аас доош хувь эзэмшигч

Хувьцааны **9.1%** хувийг **99.9%** нь эзэмшиж байна



ДАНС ЭЗЭМШИГЧИД



- 2020 оны 2 дугаар улиралд 469,214 данс нээгдэж нийт дансны тоо 2,296,933-т хүрсэн бол 130,626 холболтын данс нээгдэж холболтын дансны тоо 348,501-т хүрлээ
- 2019 оны мөн үетэй харьцуулахад нийт дансны тоо 29.4 хувиар нэмэгдсэн.



ДАНС ЭЗЭМШИГЧ


2,296,933

ҮЦТХТ-Д БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС



ҮЦК БОЛОН ХАА-Н БРОКЕРИЙН КОМПАНИУДЫН БАЙРШИЛ

- 2020 оны 2 дугаар улиралд нийт 53 ҮЦК болон тэдгээрийн 33 салбар үйл ажиллагаа явуулав. Эдгээрийг газар зүйн байршлаар харуулбал 58 нь Улаанбаатар хотод, 28 нь орон нутагт байршиж байна.
- Нийт 14 ХАА-н брокер үйл ажиллагаа явуулж байгаагийн 10 нь Улаанбаатар хотод, 4 нь орон нутагт байршиж байна.




БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

- 2020 оны 2 дугаар улиралд нийт хувьцааны арилжаа 23.5 тэрбум төгрөгт хүрсэн нь 2018 оны 2 дугаар улиралтай харьцуулахад 52.7 хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 71.5 хувиар буурчээ.


■ Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/



ЗГҮЦ–НЫ АРИЛЖАА

- 2020 оны 2 дугаар улиралд ЗГҮЦ–ны арилжаа 0.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 92.6 хувиар, 2018 оны 2 дугаар улиралтай харьцуулахад 98 хувиар тус тус буурчээ.

■ ЗГҮЦ–ны арилжаа /тэрбум төгрөг/



КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН АРИЛЖАА

- 2020 оны 2 дугаар улиралд компанийн бондын арилжаа 5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.9 тэрбум төгрөгөөр, 2018 оны 2 дугаар улиралд 4.4 тэрбум төгрөгөөр өсчээ.

■ Компанийн өрийн хэрэгслийн арилжаа /тэрбум төгрөг/



24
ТЗК

83,674
Зээлдэгч

4.4
их наяд
төгрөг

Жимобайл
вексель

7
тэрбум
төгрөг

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС


- Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох зорилгоор 2013 оноос ипотекийн бага хүүтэйгээр орон сууцны зээлийг иргэдэд олгож эхэлсэн. Өнөөгийн байдлаар “МИК ОССК” ХХК–аас 24 ТЗК үүсгэн байгуулж, нийт 83,674 зээлдэгчийн ипотекийн зээлийг үнэт

цаасжуулж 4.4 их наяд төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Хороонд бүртгүүлээд байна.

- Монгол Улсад хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг үл хөдлөх хөрөнгийн зээлээр баталгаажуулж ирсэн бөгөөд 2020 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 63,775 зээлдэгчийн 2.9 их наяд төгрөгийн баталгаат үнэт цаас байна.
- Үүрэн телефоны оператор болох “Жимобайл” ХХК хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан нь үл хөдлөх хөрөнгийн зээлээс өөр төрлийн санхүүгийн хэрэгслээр баталгаасан үнэт цаас гаргасан анхны тохиолдол болсон.

АРИЛЖААНЫ БҮТЭЦ /ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДААР/

- 2019 оны 2 дугаар улиралд нийт арилжааны дийлэнх буюу 33.8 хувийг дотоодын иргэн эзэлж байсан бол 2020 оны 2 дугаар улиралд дотоодын ААН-ийн хийсэн арилжааны гүйлгээ хамгийн их буюу 53.9 хувь байна.



○ Дотоодын ААН, 53.9%


○ Гадаадын ААН, 1.2%

○ Дотоодын иргэн, 37.9%

○ Гадаадын иргэн, 7.0%

ХУВЬЦААНЫ ӨМЧИЙН БҮТЭЦ

- 2020 оны 2 дугаар улирлын байдлаар Санхүүгийн Зохицуулах Хорооны үнэт цаасны бүртгэлд нийт 304 ХК бүртгэлтэй байна.
- Өмчийн бүтцийг задлан харвал нийт ХК-ийн 84 хувь нь хувийн өмчит, 10 хувь нь төрийн өмчит, 6 хувь нь төрийн өмчийн оролцоотой байна.




○ Хувийн өмчит 84%

○ Төрийн өмчит оролцоотой 6%

○ Төрийн өмчит 10%

АШИГТ АЖИЛЛАГАА




ҮЦК-ИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

- o ҮЦК-уудын нийт хөрөнгө 2020 оны 2 дугаар улиралд 98.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар өссөн үзүүлэлт юм.
- o Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого 0.9 тэрбум төгрөгөөр, зарлага 1.5 тэрбум төгрөгөөр, ашиг 4.9 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.

- o 2020 оны 2 дугаар улирлын орлогыг тооцохдоо үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн цэвэр орлого болон үнэт цаасны арилжааны цэвэр орлогыг хасаж тооцсон болно.


ҮЦК-ИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ

● Брокерийн үйл ажиллагааны орлого	51.6%
● Андеррайтерийн үйл ажиллагааны орлого	21.6%
● Хүүгийн орлого	6.9%
● Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааны орлого	8.1%
● Бусад орлого	3.5%
● Ногдол ашгийн орлого	5.0%
● Бусад үйл ажиллагааны орлого	1.4%
● Дилерийн үйл ажиллагааны орлого	0.8%
● Түрээсийн орлого	1.0%




ҮЦК-ИЙН ЗАРДЛЫН БҮТЭЦ

● Борлуулалт, маркетингийн болон ерөнхий удирдлагын зардал	89.2%
● Санхүүгийн зардал	9.2%
● Бусад зардал	1.7%



ХОМК-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХОМК-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




ХОМК-ИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

- ХОМК-ийн нийт хөрөнгө 2020 оны 2 дугаар улиралд 18.0 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 38.5 хувиар өсчээ.
- Орлого 0.9 тэрбум төгрөгөөр, зарлага 0.8 тэрбум төгрөгөөр өсөж, цэвэр алдагдал өөрчлөлтгүй байна.


ОРЛОГЫН БҮТЭЦ

● Үйл ажиллагааны орлого	86.7%
● Хүүгийн орлого	0.2%
● Ногдол ашгийн орлого	0.01%
● Бусад орлого	13.1%



ЗАРДЛЫН БҮТЭЦ



● Борлуулалт, маркетингийн болон ерөнхий удирдлагын зардал	95.2%
● Санхүүгийн зардал	4.8%



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ТОП-20 ИНДЕКСИЙН ХЭЛБЭЛЗЭЛ

- Хувьцааны үнийн хэлбэлзлийг ТОП-20 индексийн хүрээнд тооцон гаргалаа. Хувьцааны үнийн хэлбэлзэл 2020 оны 2 дугаар улиралд 1,294.5 нэгж байгаа нь өмнөх оны мөн үеэс 578.7 пунктээр өссөн үзүүлэлт.



MSE A БОЛОН MSE Б ИНДЕКСИЙН ХЭЛБЭЛЗЭЛ

- Хувьцааны үнийн хэлбэлзлийг MSE A болон MSE Б индексүүдийн хувьд тооцож үзэхэд 2020 оны 2 дугаар улиралд MSE A индексийн хэлбэлзэл 323.7 пунктээр өссөн, MSE Б индексийн хэлбэлзэл 132.7 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна.

IPO ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ

- 2005 оноос 2020 оны 2 дугаар улирал хүртэл нийт 27 компани IPO хийж нийт 155.9 тэрбум төгрөгийн хөрөнгийг анхдагч зах зээлээс татан төвлөрүүлээд байна.



FPO

8
компани

31.6
тэрбум
төгрөг

КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

- Монголд бондын анхдагч зах зээлийн арилжаа анх 2001 онд явагдаж байв. 2001 оноос хойш 2020 оны 2 дугаар улирал хүртэл давхардсан тоогоор 15 компани 17 удаагийн арилжаагаар нийт 30.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг татан төвлөрүүллээ. 2020 оны 2 дугаар улиралд нэг компанид олон нийтэд санал болгох өрийн хэрэгсэл гаргах зөвшөөрлийг олгосон.

FPO ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ

- Монголын анхны Follow on Public Offering (FPO) буюу нэмж хувьцаа гаргах замаар хөрөнгө татан төвлөрүүлэх арилжаа 2007 онд явагдаж байв. 2007 оноос хойш давхардсан тоогоор 8 компани 10 удаагийн арилжаагаар нийт 31.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг нэмэлт хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлжээ. 2020 оны 2 дугаар улиралд нэг компанид нэмж хувьцаа гаргах зөвшөөрөл олгосон.



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

о Олон Улсын Санхүүгийн Корпораци /ОУСК/-тай хамтран “Монгол Улсад Ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд байгальд орчинд ээлтэй бизнесийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар дотоодын хөрөнгийн зах зээл дээрээс урт хугацааны санхүүжилт татахад хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, зохицуулалтын бодлогоор дэмжих, мөн байгаль орчин, нийгэм, засаглал /ESG/-ын олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна.



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

о Сүүлийн үед дотоодын хөрөнгийн зах зээлд хаалттай компани /ХХК/-ууд урвуу нэгдэх ажиллагаа /Reverse Merger/-г хэрэгжүүлэх замаар хөрөнгийн биржид бүртгэлтэй компанитай нэгдэн олон нийтийн компани болох нь ихэсч байгаатай холбогдуулан урвуу нэгдэх ажиллагааны талаар олон улсын зохицуулалтыг судлан үзэж холбогдох санал, дүгнэлтийг гаргасан. Цаашид дотоодын томоохон аж ахуйн нэгж байгууллагуудыг урвуу нэгдэх ажиллагааны оронд олон нийтэд анх удаа үнэт цаасаа санал болгох /IPO/ ажиллагааг идэвхжүүлэх замаар хөрөнгийн биржид бүртгэлтэй болгох бодлогын чиглэлийг баримтлахаар болсон ба энэ талаар холбогдох чиглэлийг Монголын хөрөнгийн биржид хүргүүлээд байна.

- о Хорооны 2019 оны 4 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д банк үнэт цаасны зах зээлд андеррайтер, кастодиан, санхүүгийн зөвлөх компани болсон нөхцөлд хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, гүйцэтгэх удирдлагыг өөрчилсөн тохиолдолд хэрхэн зохицуулах талаар болон Хорооны 2015 оны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д арилжааны банк шинээр болон нэмж үнэт цаас гаргах, нэгдэж нийлэх, хаалттай хүрээнд өрийн хэрэгсэл гаргахад тавигдах шаардлага, бүрдүүлэх бичиг баримтыг хянахтай холбоотой зохицуулалтын нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.
- о Хорооны Ажлын албаны даргын 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн Б/106 дугаар тушаалаар “Үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийн номинал дансны зохицуулалтыг боловсронгуй болгох, Үнэт цаас зээлдэх, зээлдүүлэх харилцааны нарийвчилсан журмыг боловсруулах, Итгэмжилсэн дилер буюу зах зээл үүсгэгчийн тогтолцоог бүрдүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг байгуулсан. Уг ажлын хэсгийн зүгээс хөрөнгийн зах зээл дээр зах зээл үүсгэгч, түүний үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлж, шаардлагатай асуудлуудыг хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр санал нэгдэн дээрх журмын төслийг эхний байдлаар боловсруулаад байна.
- о “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 13 дугаар тогтоолоор “Үнэт цаасны клирингийн журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, клирингийн үйлчилгээний шимтгэлийг “цэвэршүүлсэн үнийн дүнгээс” буюу клирингийн гишүүнд хамаарах тухайн өдрийн авах зарах хэлцлийн зөрүү үнийн дүнгээс суутган авахаар болсон. Мөн мөнгөн хөрөнгийн төлбөрийн үүргийг “ҮЦТХТ” ХХК-д шилжүүлсэнтэй холбогдуулан анхдагч зах зээлийн арилжааны шимтгэлийг “ҮЦТХТ” ХХК холбогдох журамдаа нэмэлт, өөрчлөлт оруулсны дараа суутган авахаар болсон ба Хорооны зүгээс анхдагч зах зээлийн арилжааны шимтгэлийг 50 хувиас багагүй хэмжээгээр бууруулах чиглэлийг өгч ажилласан.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

о “Нийслэлийн Орон Сууцны Корпораци” хаалттай ХК-аас хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахаар бэлтгэж байгаатай холбоотойгоор хууль, журмын зохицуулалтуудын хүрээнд үнэт цаасжуулах процесс явуулах талаар хэлэлцэх, зөвлөх уулзалтуудыг хийсэн бөгөөд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах схемийн загварыг боловсруулан өгч, түрээсийн үйл ажиллагаанд суурилсан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг зах зээлд шинээр нэвтрүүлэхэд холбогдох зөвшөөрлийг өгөхөөр ажиллаж байна.

- о Олон улсын санхүүгийн корпораци /ОУСК/-аас Санхүүгийн зохицуулах хороотой хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад Ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд 2020 оны 6 дугаар сарын 19-ний өдөр “Ногоон бондын зах зээлийг хөгжүүлэх нь” сэдэвт вебинар хэлэлцүүлгийг олон нийтэд нээлттэй зохион байгуулсан.



ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Нийт хөрөнгө

359.2 тэрбум төгрөг

Хөрөнгийн өсөлт **1.3%**



Санхүүгийн зах зээлийн төлөв

Даатгалын нягтрал

60,708 төгрөг

Нягтралын өсөлт
8%



Хүртээмжтэй байдал

Зуучилсан даатгалын
болон давхар даатгалын
хураамж

27.2 тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн үйлчилгээ



Ашигт ажиллагаа



Цэвэр ашиг
11.7
тэрбум төгрөг



Тогтвортой байдал



Давхар даатгалын нийт
хураамжийн эзлэх хувь
26.2%

Бодлого зохицуулалт



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН БҮТЭЦ



СЗХ–ноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн бүртгэлийн хүрээнд тайлант улиралд нийт 143 даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч, аудитын компани, 32 актуарч, 144 аудитор мөн 2,453 даатгалын төлөөлөгч үйл ажиллагаа явуулсан.



* Давхар даатгалын зуучлагч давхардсан тоогоор орсон болно.

ДААТГАЛЫН ГҮНЗГИЙРЭЛТ

2020 оны 2 дугаар улиралд даатгалын гүнзгийрэлт 0.57 хувьд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.07 хувиар буурсан байна.




ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН НИЙТ ХӨРӨНГӨ

- Тайлант улиралд нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар өсөж 359.2 тэрбум төгрөгт хүрлээ.
- Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн жилийн өсөлт бусад даатгалын төрөлтэй харьцуулахад өмнөх оны мөн үеэс 8 хувиар өсөж 293.9 тэрбум төгрөгт хүрч, салбарын нийт хөрөнгийн 81.8 хувийг эзэлж байна.
- Давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.1 хувиар буурч, 55.7 тэрбум төгрөг хүрсэн нь салбарын нийт хөрөнгийн 15.5 хувийг эзэлж байна. 2020 оны 1 дүгээр улирлаас 1 давхар даатгалын компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбоотойгоор давхар даатгалын хөрөнгийн өсөлт өмнөх үетэй харьцуулахад буурсан байна.
- Урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар өсөж, 9.6 тэрбум төгрөгт хүрч, салбарын 2.7 хувийг эзэлж байна.

ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ БҮТЭЦ /НИЙТ ХӨРӨНГӨӨР/

Даатгалын компаниудыг нийт хөрөнгөд эзлэж буй хувиар нь авч үзвэл 9 хувиас дээш хувийг 3 даатгалын, 6–9 хувийг 4 даатгалын, 3–6 хувийг 4 даатгалын, 3 хувиас доош хувийг 6 даатгалын компани бүрдүүлж байна.


Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзлэх хувь




ДААТГАЛЫН КОМПАНИЙН ХӨРӨНГИЙН ӨСӨЛТИЙН ТАРХАЛТ

Нийт даатгалын компаниудын хөрөнгийн дундаж өсөлт 2019 оны 2 дугаар улиралд 20.4 хувь байсан бол тайлант улиралд -0.9 хувьтай байна. Харин хөрөнгийн өсөлтөөр бүлэглэвэл 30 хувиас дээш өсөлттэй 2, 20-30 хувийн өсөлттэй 1, 10-20 хувийн өсөлттэй 2, 10 хувиас доош өсөлттэй 9, нийт хөрөнгийн хэмжээ буурсан 3 компани байна.

2019.II/2020.II



- Ердийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж
- Ердийн болон урт хугацааны даатгалын давхар даатгалын хураамж
- Дотоодын давхар даатгалын компанийн нийт хураамж




НИЙТ ХУРААМЖ

- Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд 2020 оны 2 дугаар улиралд нийт 94.8 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлжээ. Үүнээс: ердийн даатгалын компаниуд 94.1 тэрбум төгрөг буюу 99.2 хувь, урт хугацааны даатгалын компани 0.7 тэрбум төгрөг буюу 0.8 хувийг бүрдүүлжээ.
- Нийт 24.8 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжид зарцуулсны 1.6 тэрбум төгрөг буюу 6.3 хувийг дотоодын давхар даатгагчид төлжээ.
- 2020 оны 2 дугаар улирлын ердийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.5 хувиар буурчээ.

ДААТГАЛЫН БОЛОН ДАВХАР ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

- Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 2020 оны 2 дугаар улиралд 27.7 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 7.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 99.1 хувийг бүрдүүлжээ.
- Тайлант хугацаанд давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрийн хэмжээ 67.3 хувиар өсөж 1.9 тэрбум төгрөгт хүрсэн байна.



НӨӨЦ САН

- Даатгалын салбарын нийт нөөц сангийн хэмжээ тайлант улиралд өнгөрсөн оны мөн үеэс 0.5 хувиар өсөж 159.7 тэрбум төгрөгт хүрсэн.
- Тайлант улиралд ердийн даатгалын компаниудын нийт нөөц сангийн хэмжээ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.2 хувиар өсөж 130.8 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын компанийн нөөц сан 18.0 хувиар өсөж 2.6 тэрбум төгрөг, давхар даатгалын компанийн нөөц сан 0.9 хувиар өсөж 26.3 тэрбум төгрөг болов.

159.7
Тэрбум төгрөг
2020.ИИ

158.9
Тэрбум төгрөг
2019.ИИ



ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ДААТГАЛЫН НЯГТРАЛ



Даатгалын нягтралын үзүүлэлт буюу нэг хүнд ногдох хураамжийн орлогын харьцаа нь салбарын хүртээмж, эрэлтийг илэрхийлдэг. Хүн амын тоог жилд нэг удаа тооцдог тул даатгалын нягтралыг улирлаар тооцох боломжгүй юм. Иймд 2019 оны жилийн эцсийн байдлаар үзүүлээ.

Даатгалын нягтралыг ангиллаар авч үзвэл, нэг хүнд ногдох ердийн даатгалын хураамж 9.2 хувиар өсөж 60,315 төгрөг болсон бол урт хугацааны даатгалын хураамж 12.1 хувиар буурч 393 төгрөгт хүрсэн байна.

ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ТОО


2020 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 0.7 сая даатгалын гэрээ байгуулагдсан байна. Үүнээс 82.8 хувь нь буюу 553,416 нь хувь хүнтэй байгуулсан даатгалын гэрээ, 17.2 хувь буюу 114,733 нь хуулийн этгээдтэй байгуулсан даатгалын гэрээ байв.

ХУВЬ ХҮН **553,416**

ХУУЛИЙН
ЭТГЭЭД **114,733**



Даатгалын үйлчилгээний хүртээмжийг илэрхийлэгч өөр нэгэн үзүүлэлт нь даатгалын компанийн салбар, зуучлагчдын тоо юм. Даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч компаниудын нийт 2,236 салбар, төлөөлөгчийн газар 21 аймагт байршиж байна. Эдгээрийг бүсээр ангилан харвал, хангайн бүсэд хамгийн их буюу 702, төвийн бүсэд 674, баруун бүсэд 571, зүүн бүсэд хамгийн бага буюу 289 салбар, төлөөлөгчийн газар тус тус үйл ажиллагаа явуулж байна.



ТӨЛӨӨЛӨГЧИД


500

605

526

238

- Тайлант хугацаанд Улаанбаатар хотод нийт даатгалын компанийн 54, даатгалын зуучлагчийн 178, хохирол үнэлэгчийн 38 салбар Хороонд бүртгэлтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.
- Эдгээрийг дүүргээр ангилан үзвэл салбар нэгжийн 92.9 хувь нь төвийн 6 дүүрэгт төвлөрчээ.
- Түүнчлэн Хороонд бүртгэлтэй даатгалын компанийн төлөөлөгчийн газар 12 байгаагаас БНСУ болон БНХАУ-д тус тус нэг төлөөлөгчийн газар байна.



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ



- o Ердийн болон урт хугацааны даатгалын нийт 23 хэлбэрээс “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал”-аас бусад нь сайн дурын даатгалын хэлбэр юм.

Даатгалын нийт хураамж



Даатгалын нөхөн төлбөр




АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нийт хураамж тайлант улиралд 21.1 тэрбум төгрөгт хүрч, нийт даатгалын хураамжийн орлогын 22.3 хувийг эзэлж байна. Нөхөн төлбөрийн хувьд өнгөрсөн оны мөн үеэс 5.5 хувийн бууралттай байна.
- Энэ улиралд 8.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр тус хэлбэрээр олгосон нь салбарын нийт нөхөн төлбөрийн зардлын 31 хувийг бүрдүүлжээ.



ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧИД

- 2020 оны 2 дугаар улиралд даатгалын зуучлагчдын төвлөрүүлсэн даатгалын болон давхар даатгалын хураамж 27.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин даатгалын зуучлагчдын зуучлалын шимтгэлийн орлого өнгөрсөн оны мөн үед 5.2 тэрбум төгрөг байсан бол тайлант улиралд мөн үеэс 185.4 сая төгрөгөөр өсөж, 5.4 тэрбум төгрөгт хүрэв.



ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧИД


- Тайлант улиралд даатгалын хохирол үнэлэгч компаниуд нийт 13,540 хохирлыг 12.1 тэрбум төгрөгөөр үнэлэв. Нийт даатгалын хохирол үнэлгээний орлого өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 49.3 сая төгрөгөөр буурч, 482.9 сая төгрөгт хүрэв.



АШИГТ АЖИЛЛАГАА



ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН ЦЭВЭР АШГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

- Тайлант улиралд даатгалын компаниудын цэвэр ашиг өнгөрсөн онтой харьцуулахад 832.7 сая төгрөгөөр буурч 11.7 тэрбум төгрөгт хүрсэн.
- Татварын дараах цэвэр ашгийн өсөлтийг бүлэглэн авч үзвэл цэвэр ашгийн хэмжээ буурсан 4, 50 хувь хүртэлх өсөлттэй 9, 50–100 хувийн өсөлттэй 0, 100 хувиас дээш өсөлттэй 4 даатгалын компани байна.



ГОЛЛОХ ХАРЬЦААНУУД

- Хохирол нөхөлтийн харьцаа тайлант улиралд өнгөрсөн онтой харьцуулахад 1.2 пунктээр буурсан үзүүлэлттэй байв.
- Зардлын харьцаа өмнөх оны мөн үеэс 0.9 пунктээр буурч 45.3 хувь болжээ.
- Даатгалын салбарын цэвэр ахиуц ашгийн харьцаа тайлант улиралд 0.1 пунктээр өсөж 12.2 хувьд хүрлээ.



АШИГТ АЖИЛЛАГААНЫ КОЭФФИЦИЕНТ

- Салбарын өөрийн хөрөнгийн өгөөж 2019 оны 2 дугаар улиралд 7.3 хувьтай байсан бол 2020 оны 2 дугаар улиралд 0.4 пунктээр буурч 6.9 хувьд хүрлээ.
- Нийт хөрөнгийн өгөөжийн хувьд 2019 оны 2 дугаар улиралд 3.7 хувьтай байсан бол 2020 оны 2 дугаар улиралд 0.4 пунктээр бууран 3.3 хувьд хүрлээ.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

- Монгол Улсын даатгалын зах зээлийн тулгамдаж буй асуудлын нэг нь валютын ханшийн эрсдэл юм.
- Даатгалын компаниудын дийлэнх нь гадаад улсад давхар даатгуулдаг бөгөөд сүүлийн гурван жилийн хугацаанд 1 жилд дунджаар 50 гаруй тэрбум төгрөгийг гадаад улсруу шилжүүлсэн.
- Даатгалын компаниудын гадаад улсад төвлөрүүлсэн давхар даатгалын хураамжийн зардал тайлант улиралд даатгалын нийт хураамжийн 26.2 хувьтай тэнцэж байна.

26.2%

Давхар даатгалын хураамжийн нийт хураамжид эзлэх хувь

- Тайлант улиралд даатгалын компаниудын нийт хөрөнгийн 60.8 хувийг хөрөнгө оруулалт, үүний 84.9 хувийг хадгаламж, хадгаламжийн сертификат хэлбэрээр хийсэн хөрөнгө оруулалт бүрдүүлж байна.
- Хадгаламж, хадгаламжийн сертификат болон үнэт цаасаарх хөрөнгө оруулалтаас даатгалын компаниуд 2020 оны 2 дуар улиралд нийт 12 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олсон байна.


60.8%

Хөрөнгө оруулалтын дүн

Давхар даатгалын хураамж



Даатгалын нийт хөрөнгө оруулалт ба хадгаламжийн жигнэсэн дундаж хүү



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-аас Монгол Улсад 2021 онд хэрэгжүүлэх техникийн хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрийн хүрээнд Даатгалын газраас “Даатгалын мэдээллийн нэгдсэн сан” бий болгох саналыг төслийн хамт хүргүүлсэн.
- Азийн хөгжлийн банкны “ТА-9808 МОН: Санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хуулийн зохицуулалтыг хөгжүүлэх” төслийн хүрээнд шаардсан мэдээллийг Азийн хөгжлийн банканд хүргүүлж цаашдын хамтын ажиллагаагаа дэмжин ажиллаж байна.
- Олон улсын даатгалын хянан шалгагчдын холбоо /IAIS/-ноос ирүүлсэн COVID-19-тэй холбоотойгоор олон улсын даатгалын салбарт гарч буй нөлөө болон улс орнуудын авч буй хариу арга хэмжээний талаар судалгаа бэлтгэж, салбарын тогтвортой байдлыг хангах Монгол Улсад авч болох хариу арга хэмжээг тодорхойлсон. Энэ дагуу коронавирустэй холбогдох шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ Монгол Улсын даатгалын зах зээлд нэвтэрсэн.



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Хорооны 2020 он 114 дүгээр тогтоолоор “Даатгалын зах зээлийн ёс зүйн журам”-ыг баталсан бөгөөд энэхүү журам хэрэгжсэнээр зах зээлд оролцогч бүр ёс зүйн дүрэмтэй болж, мөрдөн хэвших, хариуцлага тооцох тогтолцоо бүрдэж, зах зээлийн ёс зүйн харилцаа сайжрах ач холбогдолтой юм.
- Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудын нэмэлт, өөрчлөлтийн төслүүдийн үзэл баримтлал, тандан судалгаатай танилцаж, холбогдох саналыг Сангийн яаманд хүргүүлж ажилласан бөгөөд одоогийн байдлаар эдгээр хуулийн төслүүдийн үзэл баримтлал батлагдаад байна.
- Хорооны 2020 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 165, 166 дугаар “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын мэдүүлгийн маягт, гэрээний стандарт, загварт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тус баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 3947, 3948 дугаарт тус тус бүртгүүлсэн.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- “Даатгал” сэдэвт 2 теле хичээлийг бэлтгэж, STAR телевизээр 2020 оны 4 дүгээр сарын 24, 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдрүүдэд тус тус нэвтрүүлж олон нийтэд хүргэсэн ба 2020 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Монголын үндэсний радио телевиз болон Монгол банкны хамтарсан Мөнгөний мод нэвтрүүлгээр “Даатгалын ач холбогдол” сэдвийн хүрээнд аудио шууд эфирээр дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэсэн.
- Хорооноос зохион байгуулсан Улсын Их Хурлын эдийн засгийн байнгын хорооны ажилтнуудад чиглэсэн “Санхүүгийн зах зээл” сэдэвт сургалтаар Даатгалын зах зээлийн зохицуулалтын талаар танилцуулга хийсэн.



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Нийт хөрөнгө

1.9

их наяд төгрөг



Санхүүгийн зах зээлийн төлөв

Хөрөнгийн өсөлт

21.5%

Дундаж зээлийн хэмжээ

2.9 сая төгрөг

Харилцагч

2.8 сая



Хүртээмжтэй байдал

Зээлийн ББСБ

91.9%

8.1%

Зөвхөн гадаад валютын
арилжааны ББСБ



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Нийт орлого

200.2

тэрбум төгрөг

Тогтвортой байдал



Z индекс

26.1

Чанаргүй зээлийн
эзлэх хувь

8.7%

Бодлого зохицуулалт



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

- 2020 оны 2 дугаар улиралд Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр 542 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулав.
- Эдгээрийн 77 буюу 14.2 хувь нь орон нутагт, 465 буюу 85.8 хувь нь нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна.





Нийт банк бус санхүүгийн байгууллагуудын 5.7 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтаар, 94.3 хувь нь үндэсний хөрөнгө оруулалттай байна.



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨРӨНГӨ

2020 оны 2 дугаар улиралд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгийн хэмжээ 1.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 329.0 тэрбум төгрөгөөр буюу 21.5 хувиар өсчээ.





ББСБ-уудын активын бүтэц /тэрбум төгрөгөөр/

Нийт хөрөнгийн дүн	1,862.2	100.0%
Эргэлтийн хөрөнгө	1,791.4	96.2%
Мөнгөн хөрөнгө	395.3	21.2%
Зээл /цэврээр/	1,218.5	65.4%
Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	10.3	0.6%
Факторингийн тооцооны авлага /цэврээр/	2.9	0.2%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	12.9	0.7%
Бусад хөрөнгө	151.6	8.1%
Эргэлтийн бус хөрөнгө	70.7	3.8%




ББСБ-уудын пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/


Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	1,862.2	100.0%
Өр төлбөр	524.5	28.2%
Санхүүгийн эх үүсвэр	118.6	6.4%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	212.3	11.4%
Бусад эх үүсвэр	33.2	1.8%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	52.3	2.8%
Төслийн зээлийн санхүүжилт	23.4	1.3%
Бусад өр төлбөр	84.5	4.5%
Эздийн өмч	1,337.7	71.8%
Хувьцаат капитал	977.3	52.5%
Бусад өмч	32.9	1.8%
Сангууд	0.7	0.0%
Хуримтлагдсан ашиг/ алдагдал	325.9	17.5%
Хоёрдогч өглөг	0.8	0.0%




8 ББСБ



180 ББСБ



44 ББСБ



542 ББСБ


Зах зээлд эзлэх хувь хэмжээ буюу нийт хөрөнгөд эзлэх хувиар нь харвал салбарын нийт хөрөнгийн

- 25 хувийг хамгийн их хөрөнгө бүхий 8 ББСБ;
- 50 хувийг хамгийн их хөрөнгө бүхий 44 ББСБ;
- 75 хувийг хамгийн их хөрөнгө бүхий 180 ББСБ эзэлж байна.

Нийт зээл /тэрбум төгрөг/



Зээлийн хүү: 2020 оны 2 дугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.9 хувьд хүрч буурлаа.



НИЙТ ЗЭЭЛ

2020 оны 2 дугаар улирлын байдлаар салбарын нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 19.2 хувиар буюу 210.6 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй байна.

2020 оны 2 дугаар улирлын байдлаар нийт зээлийн үлдэгдлийн 97.6 хувийг төгрөгөөр олгосон зээл, үлдсэн 2.4 хувийг валютаар олгосон зээл эзлэж байна.

97.6%



ХЭВИЙН

86.5%



ХУГАЦАА ХЭТЭРСЭН

4.8%



ЧАНАРГҮЙ

8.7%

778.5 тэрбум төгрөг | Олгосон зээл

Төлөгдсөн зээл | 717.5 тэрбум төгрөг

Хэрэглээ



64.7%

66.4%

Бөөний болон жижиглэн худалдаа



12.0%

13.4%

Барилга



7.4%

6.3%

Уул, уурхай олборлолт



1.3%

2.3%

Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйлчилгээ



3.4%

2.1%

Машин, мотоциклийн засвар үйлчилгээ



2.1%

1.7%

Боловсруулах үйлдвэр



1.2%

1.4%

Бусад





7.3%

6.4%

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ


Улсын хэмжээнд тусгай зөвшөөрөлтэй 542 банк бус санхүүгийн байгууллага нь 273 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаагаас 85.8 хувь нь Улаанбаатар хотод, 14.2 хувь нь хөдөө орон нутагт байршиж байна.






Олон улсын санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ээс санхүүгийн хүртээмжийг тооцоход сонголттой байдлын үзүүлэлт болох дор хаяж 3 санхүүгийн байгууллага бүхий засаг захиргааны нэгжийн хувийг тооцохыг зөвлөсөн байдаг. Нийт 21 аймгийн 52.4 хувь буюу 11 аймагт 3 буюу түүнээс дээш тооны банк бус санхүүгийн байгууллага байна.

1 000 аж ахуйн нэгжид ногдох



100 000 хүн амд ногдох



Улаанбаатарт үйл ажиллагаагаа явуулж буй 465 ББСБ-ын 35.3 хувь нь Сүхбаатар дүүрэгт, 30.3 хувь нь Чингэлтэй дүүрэгт, 15.3 хувь нь Баянгол дүүрэгт, 10.8 хувь нь Баянзүрх дүүрэгт, 6.7 хувь нь Хан-Уул дүүрэгт, 1.5 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, 0.2 хувь нь Багануур дүүрэгт тус тус үйл ажиллагаагаа явуулж байна.

ББСБ-УУДЫН ХҮРТЭЭМЖ, ГАЗАРЗҮЙН БАЙРШЛААР

- Монгол Улсын хэмжээнд 18–64 насны 100,000 иргэнд 26 банк бус санхүүгийн байгууллага, 1,000 аж ахуйн нэгжид 26 банк бус санхүүгийн байгууллага ногдож байна.
- Орон нутгийн хэмжээнд уг харьцаанууд нь 10, 5 байгаа бөгөөд бүс нутгийн хувьд Төвийн бүс 100,000 иргэнд 14, 1,000 аж ахуйн нэгжид 7 банк бус санхүүгийн байгууллага ногдож байгаагаар банк бус санхүүгийн байгууллагын хүртээмжээр тэргүүлж байна.

Улсын хэмжээнд
100 000 хүнд

26
ББСБ

1 000 аж
ахуйн нэгжид


26
ББСБ




ДУНДАЖ ЗЭЭЛ

- 2020 оны 2 дугаар улиралд Монгол Улсын хэмжээнд ББСБ-аас нэг зээлдэгч дунджаар 2.9 сая төгрөгийн зээл авсан бол орон нутагт энэхүү үзүүлэлт 3.1 сая төгрөг, Улаанбаатар хотын хувьд 2.9 сая төгрөгийн зээлтэй байна.
- Харин уг үзүүлэлт өмнөх оны мөн үед улсын хэмжээнд 3.0 сая төгрөг байсан ба тайлант улирлын хувьд банк бус санхүүгийн байгууллагаас зээл авсан нэг зээлдэгчид ногдох зээлийн дундаж хэмжээ 4 хувиар буюу 112.2 мянган төгрөгөөр буурчээ.
- Нийт зээлдэгчдийн тоо 446.0 мянга байгаа нь давхардсан тоогоор хөдөлмөрийн насны буюу 18–64 насны 100 хүн тутмын 14 нь ББСБ-аас зээлтэй байна гэсэн үг юм.


Банк бус санхүүгийн байгууллагын харилцагчид



Банк бус санхүүгийн байгууллагын зээлдэгчид /насны бүлгээр/



Банк бус санхүүгийн байгууллагын зээлдэгчид /боловсролын түвшингээр/



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР /ДАВХАРДСАН ТООГООР/



БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО

- 2020 оны 2 дугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын нийт орлого 200.2 тэрбум төгрөгт хүрэв.
- Нийт орлогын 98.0 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу хүүгийн болон хүүгийн бус орлого бүрдүүлж байна. Үүнээс нийт орлогын 81.7 хувь буюу 163.7 тэрбум төгрөгийг хүүгийн орлого, 16.2 хувь нь буюу 32.5 тэрбум төгрөгийг хүүгийн бус орлого бүрдүүлж байна.

- Хүүгийн орлого
- Хүүгийн бус орлого
- Үндсэн бус үйл ажиллагааны орлого
- Үндсэн үйл ажиллагааны орлого




- Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого
- Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого
- Арилжааны орлого
- Картын үйлчилгээний орлого
- Мөнгөн гуйвуулгын орлого
- Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого
- Бусад

ХҮҮГИЙН БУС ОРЛОГЫН ЗАДАРГАА

- Хүүгийн бус орлогын 51.7 хувийг үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого, 20.7 хувийг ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого, 7.1 хувийг арилжааны орлого, 3.3 хувийг картын үйлчилгээний орлого, 1.9 хувийг мөнгөн гуйвуулгын орлого, 0.4 хувийг санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого, 14.9 хувийг бусад орлого тус тус бүрдүүлж байна.


- Факторингийн үйлчилгээ гэдэг нь зээлдүүлэгч буюу үүрэг гүйцэтгүүлэгчээс мөнгөн төлбөрийн үүргийг шаардах эрхээ гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах, энэхүү эрхийг хүлээн авагч нь эрхээ хэрэгжүүлэх болон үүсэн гарах үр дагаврыг бүхэлд нь хариуцах үйл ажиллагааг хэлдэг. 2020 оны 2 дугаар улирлын байдлаар салбарын хэмжээнд нийт 2.9 тэрбум төгрөгийн факторингийн цэвэр авлага бүртгэлтэй байна.

Факторингийн үйлчилгээний цэвэр авлага /тэрбум төгрөг/




- Салбарын хэмжээнд нийт 40 банк бус санхүүгийн байгууллага итгэлцлийн үйлчилгээг эрхэлж байна.
- Тэдгээрийн үзүүлсэн итгэлцлийн үйлчилгээний нийт өглөг 118.6 тэрбум төгрөг байгаа ба өмнөх оны мөн үеэс 41.0 хувиар өслөө.

Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөг/



Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний орлого /тэрбум төгрөг/



- 2020 оны 2 дугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагууд мөнгөн гуйвуулгын үйлчилгээнээс нийт 628.8 сая төгрөгийн орлогыг олжээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 183.9 сая төгрөгөөр өссөн үзүүлэлт юм.
- Салбарын хэмжээнд нийт 33 байгууллага уг үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаагаас тайлант улиралд 13 нь уг үйлчилгээнээс орлого олсон байна.

ХУДАЛДСАН, ХУДАЛДАН АВСАН ВАЛЮТЫН МЭДЭЭ

2020 оны 4-6 дугаар сарын байдлаар банк бус санхүүгийн байгууллагууд нийт 352.9 тэрбум төгрөгийн валют худалдан авч, 353.0 тэрбум төгрөгийн валютыг худалдсан байна. Худалдаж авсан валютын 47.3 хувийг, худалдсан валютын 47.0 хувийг АНУ-ын доллар бүрдүүлж байна.

ВАЛЮТЫН НЭР	Худалдаж авсан	Худалдсан
	Дүн /тэрбум төгрөг/	Дүн /тэрбум төгрөг/
АНУ-ЫН ДОЛЛАР	166.0	166.8
БНХАУ-ЫН ЮАНЬ	152.2	151.9
ЕВРО	23.6	22.9
ЯПОНЫ ИЕН	3.4	3.4
БНСУ-ЫН ВОН	2.6	2.7
БУСАД	5.1	5.3

ФИНТЕК



○ 2020 оны 2 дугаар улирлын байдлаар зөвхөн гар утсаар дамжуулан санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдлийн 91.5 хувийг хэвийн зээл, 2.2 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 6.3 хувийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлээ.

○ Салбарын нийт харилцагчдын 90.6 хувь нь эдгээр банк бус санхүүгийн байгууллагын харилцагчид буюу технологид суурилсан зээлийн үйлчилгээг хүртэх боломжтой байна.

○ 78.1 хувь нь зөвхөн гар утсаараа дамжуулан зээл авч байна.

90.6%

■ Финтек ■ Бусад





91.5% Хэвийн

2.2% Хугацаа хэтэрсэн зээл


6.3% Чанаргүй

Салбарын нийт зээлийн үлдэгдэлд бага хувь эзэлж байгаа ч олгосон болон төлөгдсөн зээлд эзлэх хувиас харахад эдгээр банк бус санхүүгийн байгууллагуудын зээл эргэлт сайтай байгаа нь харагдаж байна.

АШИГТ АЖИЛЛАГАА



ROE болон ROA-ийн харгалзах интервал дахь ББСБ-ын тоо /хувиар/



НИЙТ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖИЙН ХАРЬЦАА /ХӨРӨНГИЙН АНГИЛЛААР/

Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт болон өөрийн хөрөнгийн өгөөжийг хувь нийлүүлсэн хөрөнгийн ангиллаар харахад 1 тэрбумаас доош хувь нийлүүлсэн хөрөнгөтэй банк бус санхүүгийн байгууллагуудын тал хувь нь 0.6 хувиас бага нийт хөрөнгийн өгөөжтэй, 1–2.5 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй банк бус санхүүгийн байгууллагуудын тал хувь нь 3.1 хувиас бага нийт хөрөнгийн өгөөжтэй, 2.5 тэрбум төгрөгөөс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй банк бус санхүүгийн байгууллагуудын тал хувь нь 5.0 хувиас бага нийт хөрөнгийн өгөөжтэй байна. Өөрийн хөрөнгийн өгөөжийн хувьд холбогдох утгууд нь харгалзан 0.6, 3.3 болон 5.9 хувьтай байна.


ЗАРДАЛ, ОРЛОГЫН ХАРЬЦАА

Банк бус санхүүгийн байгууллагууд нэг төгрөгийн орлого олохын тулд дунджаар хэдэн төгрөгийн зардал гаргаж буйг тооцдог харьцаа болох зардал, орлогын харьцаа тайлант улиралд 46.4 хувь гарсан буюу өмнөх оны мөн үеэс 3.2 нэгжээр өсчээ. Өөрөөр хэлбэл банк бус санхүүгийн байгууллагууд 100 төгрөгийн орлого олохын тулд дунджаар 46.4 төгрөгийн зардал гаргаж байна гэсэн үг юм.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ


- o AFI буюу “Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг” –ээс санхүүгийн хүртээмж болон санхүүгийн дараах 4 үзүүлэлтийг тооцож байна. Үүнд:



ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХАРЬЦАА


- o Тайлант улиралд уг харьцаа 102.7 хувь гарч байгуулвал зохих эрсдэлийн санг бүрдүүлж чадсан бөгөөд эрсдэлийг 102.7 хувиар нөхөх чадамжтайг харуулжээ.
- o Энэ нь өмнөх оны мөн үеэс 0.7 пунктээр өссөн үзүүлэлт юм.

102.7%




ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ

Тайлант улиралд чанаргүй зээлийн хэмжээ 113.9 тэрбум төгрөгт хүрч чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 8.7 хувь болж буурлаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс 0.2 нэгжээр багасав.




ХӨРВӨХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА

- Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа буюу хөрвөх чадвар тайлант улиралд 21.2 хувь болжээ.
- 2020 оны 2 дугаар улиралд мөнгөн хөрөнгийн өсөлт 24.0 хувьтай байгаа нь нийт хөрөнгийн өсөлтөөс 2.5 пунктээр их байгаа тул хөрвөх чадвар өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр өссөн байна.



Z ИНДЕКС

Z индекс нь банк бус санхүүгийн байгууллагын дампуурах магадлалыг харуулдаг ба активын өгөөж болон өөрийн хөрөнгийн харьцааны нийлбэрийг активын өгөөжийн хэлбэлзэлд харьцуулж тооцдог. Z индексийн утга ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгийн хөшүүрэг өндөр байх үед их гарах ба өгөөжийн хэлбэлзэл ихтэй үед буюу орлогын тодорхойгүй байдал их үед бага гарна. Өөрөөр хэлбэл индексийн их утга нь эрсдэл багатай, тогтвортой байдлыг илэрхийлдэг. 2020 оны 2 дугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын Z индекс өмнөх оны мөн үеэс 1.4 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.





ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ийн “Хүртээмжтэй ногоон санхүүжилт” ажлын хэсэгт ажиллаж байна. Ажлын хэсгийн вебинар хуралд оролцож, “Хүртээмжтэй ногоон санхүү ба тогтвортой хөгжлийн зорилтуудын танилцуулга”, “Уур амьсгал ба гамшгийн эрсдэлд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх”, “Ногоон санхүүгийн салбар дахь төв банкны үүрэг” зэрэг сэдэвт хэлэлцүүлэгт оролцсон.
- Олон Улсын Санхүүгийн Корпорацитай “Ногоон санхүүжилтийг хөгжүүлэх” болон “Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн төслийг хамтран хэрэгжүүлэх” харилцан ойлголцлын санамж бичгийг тус тус байгуулсан.
- Хорооны зохицуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын мэргэжлийн холбоод болон сургалтын байгууллагуудтай хамтран ажиллаж Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж байгаа төслийн зөвлөхтэй уулзалт зохион байгуулж, салбарт эрсдэлд суурилсан хяналт шалгалт, ББСБ-уудыг чадавхжуулах чиглэлээр сургалт зохион байгуулахаар бэлдэж байна.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Олон Улсын Санхүүгийн Корпораци болон Олон Улсын Факторингийн Холбоотой хамтран “Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт болон факторингийн үйл ажиллагааг хөгжүүлэх нь” сэдэвт ББСБ-уудад зориулсан сургалтыг 2020 оны 01 дүгээр сарын 14, 15-ны өдрүүдэд хамтран зохион байгуулж 70 ББСБ-ын төлөөлөл, 10 арилжааны банкны төлөөлөл, СЗХ-оос 12 албан хаагчийг хамруулсан.
- Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ийн “Хүртээмжтэй ногоон санхүүжилт” ажлын хэсэгт ажиллаж, онлайн хурал, гишүүдэд зориулсан онлайн сургалтад тухай бүр оролцож байна.



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Нийт хөрөнгө

234.4 тэрбум төгрөг

Хөрөнгийн өсөлт **11.4%**



Санхүүгийн зах зээлийн төлөв

Нийт салбар **61**

Нийт гишүүдийн

46.0%

дээд боловсролтой



Хүртээмжтэй байдал

Хэрэглээ болон түүнтэй
холбогдох бусад зориулалтаар
олгогдсон зээл

81.6%



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Цэвэр орлого

5.2
тэрбум төгрөг

Тогтвортой байдал



Нийт зээлд эзлэх чанаргүй
зээлийн хувь

4.3%


Бодлого зохицуулалт



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

ХЗХ–ДЫН ТОО БА ГИШҮҮД

- 2020 оны 2 дугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж буй ХЗХ–дын тоо 256–д хүрч өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар буурлаа.
- ХЗХ–дын гишүүдийн тоо 2019 оны 2 дугаар улиралд 67,434 байсан бол тайлант улиралд 7.1 хувиар өсөж 72,230–т хүрчээ.



АЖИЛЛАГСАД

770

ХЗХ–дын нийт ажиллагсдын тоо өнгөрсөн оны мөн үеэс 3.4 хувиар буурсан ба нийт ажиллагсдын 72.1 хувь нь эмэгтэй

НИЙТ ГИШҮҮДИЙН


36,575

ЗЭЭЛДЭГЧ

35,385

ХАДГАЛАМЖ
ЭЗЭМШИГЧ

■ Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/ ○ Нийт хөрөнгийн өсөлт /хувь/



НИЙТ ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙ ӨСӨЛТ

- Тайлант улиралд нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар өсөж 234.4 тэрбум төгрөгт хүрлээ.
- Хөрөнгийн өсөлт өмнөх оны мөн үеэс 8.1 пунктээр буурчээ.

НИЙТ ЗЭЭЛ

165.1

ТЭРБУМ ТӨГРӨГ

НИЙТ
ХАДГАЛАМЖ

163.4

ТЭРБУМ ТӨГРӨГ

НИЙТ ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ

- Салбарын нийт хөрөнгийн 84.7 хувийг 1 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 21 ХЗХ;
- 4.3 хувийг 500 саяас 1 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй 15 ХЗХ;
- 11.0 хувийг 500 сая төгрөгөөс доош хөрөнгөтэй 220 ХЗХ эзэлж байна.

84.7%

21 ХЗХ

4.3%
15 ХЗХ11.0%
220 ХЗХ

ХЗХ-дын актив болон пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/

Нийт хөрөнгийн дүн	234.4	100.0%
Эргэлтийн хөрөнгө	230.2	98.2%
Мөнгөн хөрөнгө	59.5	25.4%
Зээл /цэврээр/	160.1	68.3%
Авлага	8.1	3.4%
Бусад эргэлтийн хөрөнгө	1.1	0.5%
Өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	1.4	0.6%
Эргэлтийн бус хөрөнгө	4.2	1.8%
Үндсэн хөрөнгө /цэврээр/	3.9	1.7%
Биет бус хөрөнгө /цэврээр/	0.2	0.1%
Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн бус хөрөнгө	0.02	0.0%
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	234.4	100.0%
Өр төлбөр	188.9	80.6%
Хадгаламж	163.4	69.7%
Богино хугацаат зээл	2.7	1.2%
Бусад богино хугацаат өр төлбөр	15.7	6.7%
Урт хугацаат өр төлбөр	7.1	3.0%
Өөрийн хөрөнгө	45.5	19.4%
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	18.2	7.8%
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.2	0.1%
Хоршоологчдын өмч	27.2	11.6%



- Нийт хөрөнгийн 98.2 хувь нь эргэлтийн хөрөнгө, үлдсэн 1.8 хувь нь эргэлтийн бус хөрөнгө байна.
- Нийт хөрөнгийн 25.4 хувийг мөнгөн хөрөнгө, 68.3 хувийг зээлийн цэвэр үлдэгдэл, 3.4 хувийг авлагын үлдэгдэл бүрдүүлж байна.
- Эх үүсвэрийн хувьд нийт хөрөнгийн 80.6 хувийг өр төлбөр, 19.4 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ



БАРУУН БҮС

45 ХЗХ

8 САЛБАР

ХАНГАЙН БҮС

24 ХЗХ

15 САЛБАР

ТӨВИЙН БҮС

22 ХЗХ


19 САЛБАР

ЗҮҮН БҮС

10 ХЗХ

12 САЛБАР

- Тайлант улиралд нийт 256 ХЗХ-ноос 155 ХЗХ нь нийслэл Улаанбаатар хотод, 101 ХЗХ нь хөдөө, орон нутагт бүртгэлтэй байна.
- Хөдөө, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын 44.6 хувь нь баруун бүсэд, 9.9 хувь нь зүүн бүсэд, 23.8 хувь нь хангайн бүсэд, 21.8 хувь нь төвийн бүсэд байршжээ.
- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 155 ХЗХ-дын 92.9 хувь нь төвийн зургаан дүүрэгт, 7.1 хувь нь алслагдмал гурван дүүрэгт байршиж байна.




“Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)”-ийн Санхүүгийн хүртээмжийн тоон мэдээллийн ажлын хэсгээс улс орнуудын санхүүгийн хүртээмжийг үнэлэх үндсэн индикаторуудыг 2013 онд гаргасан байдаг. Тус ажлын хэсгээс гаргасан индикаторуудыг ашиглан доорх байдлаар салбарын хүртээмжтэй байдлыг харуулъя. Үүнийг хөдөлмөрийн насны буюу 18–64 насны 10,000 хүнд ногдох, 1,000 аж ахуйн нэгж (ААН)-д ногдох ХЗХ-дын тоогоор илэрхийлж болно.

10 000 хүнд ногдох ХЗХ-ны тоо



1 000 ААН-д ногдох ХЗХ-ны тоо



- 1,000 ААН-д ногдох ХЗХ-ны тоогоор Багануур дүүрэг 6.2, Налайх дүүрэг 6.1 үзүүлэлттэйгээр тус тус тэргүүлж байгаа бол Баянгол дүүрэг 0.4 гэсэн үзүүлэлттэйгээр хамгийн доогуур жагсаж байна.
- Харин 10,000 хүнд ногдох ХЗХ-ны тоогоор Багахангай, Сүхбаатар, Налайх дүүргүүд тус тус 3.8, 3.4, 3.4 гэсэн үзүүлэлтээр тэргүүлж байна.

¹ <https://www.afi-global.org/sites/default/files/publications/fidwg-core-set-measuring-fi.pdf>



Хүртээмжийн үзүүлэлтийг 4 бүсээр ангилахад баруун бүс 10,000 хүнд ногдох, 1,000 ААН-д ногдох ХЗХ-дын тоогоор бусад бүсээс илүү сайн үзүүлэлттэй байна.

Нэг гишүүнд ногдож буй дундаж зээл



ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

- Улсын хэмжээнд 18–64 насны 56 хүн тутмын нэг нь ХЗХ-нд гишүүнчлэлтэй, зээлийн үйлчилгээг хүртэж байна.
- Дээрх үзүүлэлт нь хөдөө, орон нутагт 88 байгаа бол Улаанбаатар хотын хэмжээнд 39 байна.
- Улсын хэмжээнд ХЗХ-ноос зээл авсан нэг зээлдэгч гишүүн дунджаар 4.5 сая төгрөгийн зээлтэй байна.
- Улаанбаатар хотын хэмжээнд энэ дүн 5.8 сая төгрөг байгаа бол хөдөө, орон нутагт 2.1 сая төгрөг байна.

ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

- Улсын хэмжээнд 18–64 насны 57 хүн тутмын нэг нь ХЗХ-нд гишүүнчлэлтэй, хадгаламжийн үйлчилгээг хүртэж байна.
- Дээрх үзүүлэлт хөдөө, орон нутагт 77 байгаа бол Улаанбаатар хотын хэмжээнд 44 байна.
- Улсын хэмжээнд ХЗХ-нд хадгаламжтай нэг хадгаламж эзэмшигч гишүүн дунджаар 4.6 сая төгрөгийн хадгаламжтай байна.
- Улаанбаатар хотын хэмжээнд энэ дүн 6.7 сая төгрөг байгаа бол хөдөө, орон нутагт 1.5 сая төгрөг байна.

Нэг гишүүнд ногдож буй хадгаламжийн дундаж хэмжээ



ХЗХ-НЫ ГИШҮҮДИЙН ХҮРТЭЭМЖ

Эрэгтэй



43.3%

Эмэгтэй



56.5%

Хуулийн этгээд



0.2%

НАСНЫ БҮЛГЭЭР

18-35 НАС



28.4%

36-45 НАС



33.0%

46-55 НАС



22.6%

55-ААС ДЭЭШ



16.0%

БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР



46.0%

ДЭЭД



13.1%

ТУСГАЙ
ДУНД



29.6%

БҮРЭН
ДУНД



8.8%

ДУНД



2.5%


БАГА

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

ХЗХ–ДЫН ЗЭЭЛ

- Тайлант улиралд нийт зээлийн хэмжээ 165.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар өслөө.
- Цэвэр зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар өсөж 160.1 тэрбум төгрөгт, зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 6.0 хувиар өсөж 4.9 тэрбум төгрөгт хүрлээ.

■ Нийт зээл /тэрбум төгрөг/ ○ Зээлийн өсөлт /хувь/



ХЭВИЙН

92.6%



ХУГАЦАА ХЭТЭРСЭН

3.1%



ЧАНАРГҮЙ

4.3%

ХЗХ–ДЫН ЗЭЭЛИЙН ЧАНАР

- Тайлант улиралд хэвийн зээл өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар өсөж 152.8 тэрбум төгрөгт хүрлээ.
- Нийт зээлийн 92.6 хувийг хэвийн зээл эзэлж байна.
- Хугацаа хэтэрсэн зээл өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар өсөж 5.1 тэрбум төгрөгт хүрлээ.
- Чанаргүй зээл 10.9 хувиар өсөж 7.1 тэрбум төгрөгт хүрлээ.

ХЗХ–ДЫН ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ


- Нийт олгосон зээлийн 81.6 хувь нь хэрэглээ болон түүнд холбогдох бусад зориулалтаар, 6.3 хувь нь бизнесийн үйл ажиллагаанд, 4.0 хувь нь хөдөө аж ахуйн салбарт олгогдсон байна.
- Нийт эргэн төлөгдсөн зээлийн 81.5 хувь нь хэрэглээ болон түүнд холбогдох бусад зориулалтаарх зээлээс, 6.9 хувь нь бизнесийн үйл ажиллагаанаас, 3.6 хувь нь хөдөө аж ахуйн салбараас эргэн төлөгдсөн байна.

ТӨЛӨГДСӨН ЗЭЭЛ

ОЛГОСОН ЗЭЭЛ



■ Нийт хадгаламж /тэрбум төгрөг/ ○ Хадгаламжийн өсөлт /хувь/



ХЗХ-ДЫН ХАДГАЛАМЖ

○ ХЗХ-дын нийт хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 10.1 хувиар өсөж 163.4 тэрбум төгрөг боллоо.

НИЙТ ХАДГАЛАМЖ

○ 98.0 хувийг хугацаатай хадгаламж, 2.0 хувийг хугацаагүй хадгаламж бүрдүүлж байна.



98%

ХУГАЦААТАЙ




2%

ХУГАЦААГҮЙ



○ Тайлант улиралд ХЗХ-дын 91.8 хувь буюу 235 нь нийт 163.4 тэрбум төгрөгийн хадгаламжтай.
○ Үлдсэн 8.2 хувь буюу 21 нь хадгаламж татаагүй байна.



НИЙТ ХАДГАЛАМЖИД ЭЗЛЭХ ХУВЬ

- 1 тэрбумаас дээш төгрөгийн хадгаламжтай 14 ХЗХ нь нийт 141.0 тэрбум төгрөг буюу салбарын нийт хадгаламжийн 86.3 хувийг;
- 100 саяас 1 тэрбум төгрөгийн хадгаламжтай 172 ХЗХ нь нийт 22.1 тэрбум төгрөг буюу салбарын нийт хадгаламжийн 13.5 хувийг;
- 10 саяас доош төгрөгийн хадгаламжтай 49 ХЗХ нь нийт 0.2 тэрбум төгрөг буюу салбарын нийт хадгаламжийн 0.1 хувийг тус тус бүрдүүлж байна.

1.5%

Хадгаламжийн
жигнэсэн дундаж
сарын хүү

2.9%

Зээлийн
жигнэсэн дундаж
сарын хүү

БУСАД ТӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БУЙ ХЗХ

2019.II

2020.II

Төслийн санхүүжилтийн үйлчилгээ, төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй ХЗХ

108

97

Санхүүгийн түрээсийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй ХЗХ

3

3

Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй ХЗХ

3

4

Салбарын зөвшөөрөлтэй ХЗХ

7

САЛБАР-27

7

САЛБАР-61

ОРЛОГО

- ХЗХ–дын нийт хүүгийн орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 9.7 хувиар өсөж 25.7 тэрбум төгрөгт хүрлээ.
- Нийт хүүгийн орлогын хамгийн өндөр хувийг буюу 96.6 хувийг зээлийн хүүгийн орлого эзэлж байна.
- Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого 3.1 хувийг, зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого 0.6 хувийг тус тус эзэлжээ.
- Санхүүгийн түрээсийн орлого 21.4 сая төгрөг байна.



ЗАРДАЛ


- ХЗХ–дын нийт хүүгийн зардал өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3.3 хувиар өсөж 14.2 тэрбум төгрөгт хүрлээ.
- Нийт хүүгийн зардлын хамгийн өндөр буюу 98.0 хувийг хадгаламжийн хүүгийн зардал эзэлж байна.
- Хүүгийн зардлын 1.9 хувийг эзэлж буй банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүү өмнөх оны мөн үеэс 41.7 хувиар өсөж 268.3 сая төгрөг болжээ.
- Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал оны мөн үеэс 75.7 хувиар буурч 0.6 сая төгрөгт хүрчээ.




АШИГТ АЖИЛЛАГАА

ХЗХ–ДЫН ОРЛОГО, ЗАРДАЛ

- Тайлант улиралд нийт ХЗХ–д 26.7 тэрбум төгрөгийн орлого, 21.6 тэрбум төгрөгийн зардал, 5.2 тэрбум төгрөгийн цэвэр орлоготой ажиллалаа.
- Цэвэр орлогын нийт орлогод эзлэх хувь өмнөх оноос 7.5 пунктээр өсөж 19.4 хувьд хүрчээ.



■ Нийт хөрөнгийн өгөөж ■ Өөрийн хөрөнгийн өгөөж




НИЙТ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ

- ХЗХ–дын өөрийн хөрөнгийн өгөөж нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.5 пунктээр өсөж 12.3 хувьд хүрлээ.
- Нийт хөрөнгийн өгөөж нь 0.9 пунктээр өсөж 2.3 хувьд хүрчээ.

ГОЛЛОХ ХАРЬЦААНУУД

- Тайлант улиралд зээлийн хүүгийн орлогын нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.6 пунктээр өсөж 15.5 хувьд хүрлээ.
- Энэхүү үзүүлэлт ХЗХ-дын зээлийн үйлчилгээнээс олж буй дундаж орлогыг харуулдаг бөгөөд тайлант хугацаанд ойролцоогоор 100 төгрөгийн зээлийн үйлчилгээнээс олсон орлого 6.4 төгрөг байна.
- Цэвэр орлогыг нийт орлогод харьцуулан тооцдог цэвэр ахиуц ашгийн харьцаа нь өмнөх оны мөн үеэс 7.5 пунктээр өсөж 19.4 хувь болжээ.



ЗАРДАЛ ОРЛОГЫН ХАРЬЦАА


- ХЗХ-дын 100 төгрөгийн орлого тутмын 81 төгрөг нь зардалд ногдож байна.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ХЗХ нь өөрийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг дараах үндсэн 4 үзүүлэлт /PEARS аргачлал/-ийн дагуу тооцож, мөрдлөг болгон ажилладаг. Үүнд:

1. Хөрөнгийн чанарын болон хамгаалалтын үзүүлэлт;
2. Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт;
3. Өгөөж, зардлын хувь хэмжээний үзүүлэлт;
4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт.

■ Чанаргүй зээл /тэрбум төгрөг/ ○ Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь




ХЗХ-ДЫН ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ

- Нийт чанаргүй зээлийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 0.7 тэрбум төгрөгөөр өсөж 7.1 тэрбум төгрөг боллоо.
- Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеэс 0.2 пунктээр өсөж 4.3 хувьд хүрлээ. Энд, ХЗХ-дын мөрдөж буй зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр энэхүү үзүүлэлт 5 хувиас бага байх ёстой.

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН АНГИЛАЛ


- Чанаргүй зээлийн ангилал дахь хэвийн бус зээлийн эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 6.4 пунктээр өсөж 34.8 хувь болжээ.
- Эргэлзээтэй зээлийн хувьд өнгөрсөн оны мөн үеэс 0.7 хувиар буурч 18.3 хувьд хүрсэн бол муу зээлийн нийт чанаргүй зээлд эзлэх хувь 46.9 хувь байна.

■ Хэвийн бус зээл ■ Эргэлзээтэй зээл ■ Муу зээл




ХЗХ–ДЫН ХӨРВӨХ ЧАДВАР:

- ХЗХ–дын нийт мөнгөн хөрөнгө болон нийт хөрөнгийн харьцаа тайлант улиралд 25.4 хувьтай байна.
- Богино хугацаат хөрөнгө оруулалт болон нийт зээлийн нийлбэрийг нийт хөрөнгөд харьцуулсан үзүүлэлт 70.5 хувьтай байна.



- Зээлийн эрсдэлийн сангийн нийт зээлд эзлэх хувь
- Зээлийн эрсдэлийн сангийн нийт хөрөнгөд эзлэх хувь



ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САН

- Тайлант улиралд ХЗХ–дын зээлийн эрсдэлийн сангийн нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үетэй адил 3.0 хувь, харин нийт хөрөнгөд эзлэх хувь 0.1 пунктээр буурч 2.1 хувьд хүрсэн байна.

Харьцаа	Зохистой хувь	Тайлант улиралд
Бусдаас авсан зээл/Нийт зээл	<20%	5.9%
Нийт хадгаламж/Нийт хөрөнгө	20%–80%	69.7%
Цэвэр зээл/Нийт хөрөнгө	60%–85%	68.3%
Хоршоологчдын өмч/Нийт хөрөнгө	>5%	11.6%
Нөөцийн сан/Хоршоологчдын өмч	>10%	19.7%
Хадгаламж хамгааллын сан/Хоршоологчдын өмч	>5%	6.5%
Тогтворжилтын сан/Хоршоологчдын өмч	>5%	6.6%
Үйл ажиллагааны зардал/Нийт хөрөнгө	<15%	2.5%

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

o Санхүүгийн зохицуулах хорооноос Азийн хөгжлийн банктай хамтран “Бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийг 2019–2020 онд хэрэгжүүлж байна. Төслийн баримт бичигт тусгагдсаны дагуу 2019 оны 5 дугаар сараас 2020 оны 01 дүгээр сард “Хадгаламж, зээлийн хоршооны эрсдэлийн удирдлага” сэдэвт семинарыг 7 удаа зохион байгуулж МХЗХҮХ-ны 23 сургагч багш, Улаанбаатар хот болон орон нутагт үйл ажиллагаа явуулдаг 69 хадгаламж, зээлийн хоршооны 197 хяналтын зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захирал, нягтлан бодогчийг хамруулсан. Үргэлжлүүлэн 2020 оны 3 дугаар сараас 10 дугаар сард семинарыг орон нутгаар бүсчлэн зохион байгуулахаар төлөвлөсөн боловч дэлхий нийтээр шинэ коронавируст “Covid-19” халдвар дэгдэж Монгол Улс гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн учраас тодорхойгүй хугацаагаар хойшлуулаад байна. Үүнтэй холбоотойгоор төслийн үргэлжлэх хугацааг сунгах асуудлыг хэлэлцэж байна.



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- o Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг салбарын оролцогчдод танилцуулах хэлэлцүүлгийг 2020 оны 01 дүгээр сарын 22–ны өдөр зохион байгуулж, мөн хуулийн төслийг 2020 оны 01 дүгээр сарын 21–ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 28–ны өдрийн хооронд Хорооны цахим хуудаст байршуулж олон нийтийн саналыг авч, холбогдох өөрчлөлтийг хийсэн. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагуулж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулсан.
- o Захиргааны ерөнхий хуульд нийцүүлж хүчингүй болгох шаардлагатай Хорооны 2012 оны 136 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооноос үзүүлэх тогтворжилтын үйлчилгээний журам”-ыг Хорооны 2020 оны 353 дугаар тогтоолоор хүчингүй болгосон.
 - o Хорооны 2020 оны 5 дугаар сарын 20–ны өдрийн хуралдаанаар хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг 3 сарын хугацаанд хүлээж авахгүй байх асуудлыг хэлэлцэж, тогтоосон хугацаанд хоршооны гишүүдийн хадгаламжийг даатгалд хамруулах, тогтворжилтын сангийн үйл ажиллагааг эхлүүлэх зэрэг урт хугацаанд салбарын тогтвортой хөгжлийг хангах ажилд бэлтгэх, хоршоодын үйл ажиллагааны эрсдэлийн түвшинг шалган тогтоох, эрсдэлд суурилсан хяналт шалгалтад шилжихтэй холбоотой бэлтгэх ажлыг хангахад авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан, төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

o Олон улсын хадгаламж, зээлийн хоршооны зохицуулагчдын зөвлөл (ICURN)-ийн 2019 оны үйл ажиллагааны тайлангийн хурал дэлхий нийтэд үүссэн цар тахлын нөхцөл байдалд тохируулан 2020 оны 6 дугаар сарын 23–24–ний өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулагдсан бөгөөд Хорооны төлөөлөл оролцсон болно.



ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Нийт хөрөнгө

111.5
тэрбум төгрөг



Санхүүгийн зах зээлийн төлөв

Нэг батлан даалтын
дундаж хэмжээ

221.6
сая төгрөг



Хүртээмжтэй байдал

Ирүүлсэн
хүсэлтийн тоо **53**

Зөвшөөрөгдсөн
хүсэлтийн тоо **27**



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Нийт орлого

3.8 тэрбум төгрөг

Нийт ашиг

3.1 тэрбум төгрөг

Тогтвортой байдал




Чанаргүй батлан
даалтын эзлэх хувь

19.5%



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ




2020 оны 2 дугаар улирлын байдлаар Сангийн нийт хөрөнгийн хэмжээ 111.5 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 115.4 хувиар буюу 2 дахин өслөө.




- Сангийн батлан даалтын үлдэгдэл 2020 оны 2 дугаар улирлын байдлаар 63.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 15.9 хувиар буюу 8.8 тэрбум төгрөгөөр өслөө.
- Батлан даалт гаргасан зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 14.6 хувиар буюу 15.5 тэрбум төгрөгөөр өсөж 121.7 тэрбум төгрөгт хүрлээ.




ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ




НИЙТ БАТЛАН ДААЛТЫН ХЭМЖЭЭ



- 2020 оны 2 дугаар улирлын байдлаар Улаанбаатар хотын хувьд нийт 4.7 тэрбум төгрөгийн 21 батлан даалт шинээр олгогджээ.
- Улаанбаатар хотод гаргасан нэг батлан даалт нь дунджаар 223.2 сая төгрөг байна.






БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

	Батлан даалт гаргуулахаар ирүүлсэн хүсэлтийн тоо	Зөвшөөрөгдсөн хүсэлтийн тоо	Эзлэх хувь
2017.ИИ	27	19	70.4%
2018.ИИ	216	97	44.9%
2019.ИИ	112	63	56.3%
2020.ИИ	53	27	50.9%


2020 оны 2 дугаар улирлын байдлаар батлан даалт гаргуулах нийт 53 хүсэлт ирснээс 27 хүсэлт нь зөвшөөрөгдсөн байна. Ирүүлсэн хүсэлтийн тоо нь өмнөх оны мөн үеэс 2.1 дахин бага байна.



Өмнөх оны мөн улиралд үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарт батлан даалт түлхүү гаргаж байсан бол тайлант улиралд бөөний болон жижиглэн худалдааны салбарт гаргасан батлан даалт нийт батлан даалтын дийлэнх хэсгийг бүрдүүлж, хөдөө аж ахуйн салбарт гаргасан батлан даалтын эзлэх хувь өсчээ.

- 2016 оны сүүл үеэс эхлэн батлан даалт гаргах дундаж хугацаа өссөн дүнтэй байна.
- 2020 оны 2 дугаар улиралд гаргасан батлан даалтын дундаж хугацаа 96.0 сар буюу 8.0 жил байна.

96.0
САР



Банкны ангиллаар

- Төрийн банк 56.8%
- Капитрон банк 28.4%
- Худалдаа хөгжлийн банк 14.7%
- Хаан банк 6.7%

2020 оны 2 дугаар улиралд Сангаас гаргасан батлан даалтын 51.1 хувийг Төрийн банк, 24.0 хувийг Худалдаа хөгжлийн банк, 18.2 хувийг Капитрон банк, 6.7 хувийг Хаан банкны зээлд гаргасан батлан даалт тус тус бүрдүүлж байна.

АШИГТ АЖИЛЛАГАА



Сангийн хүүгийн орлого

47.5%


Төслийн хүүгийн орлого

39.2%

Хөтөлбөр төслийн орлого

0.8%Бусад орлого / Батлан даалт
хураамж, шимтгэл**12.5%**



Нийт хөрөнгийн өгөөж



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

2020 оны 2 дугаар улирлын байдлаар чанаргүй батлан даалтын үлдэгдэл 12.4 тэрбум төгрөгт хүрлээ.

Чанаргүй батлан даалтын үлдэгдэл /тэрбум төгрөг/



Батлан даалтын нийт үлдэгдэлд эзлэх чанаргүй батлан даалтын хувь 19.5 болж өмнөх оны мөн үеэс 6.5 пунктээр өслөө.

- Чанаргүй батлан даалтын үлдэгдлийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 47.6 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 18.5 хувь нь үйлчилгээний салбарт, 17.6 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт 17.3 хувь нь үйлдвэрлэлийн салбарт олгосон батлан даалтууд бүрдүүлж байна.
- Жил ирэх тусам үйлдвэрлэлийн салбарын чанаргүй батлан даалтын эзлэх хувь багасаж байгаа бол үйлчилгээний салбарын чанаргүй батлан даалт өссөн байна.



Үйлдвэрлэл




Хөдөө аж ахуй



Бөөний болон жижиглэн худалдаа



Үйлчилгээ





ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАР

Зохицуулалттай этгээд

103



Салбарын төлөв

Үйл ажиллагааны
төрөл

5



Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Нийт ахиуц ашиг

71%

Бодлого зохицуулалт



САЛБАРЫН ТӨЛӨВ



Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны хүрээнд Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал (ҮХЭХЗ)-ын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд нь Хорооны зохицуулалтад тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулахаар хуульчлагдсан.

Хороо 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаар анхны ҮХЭХЗ-ын компанид тусгай зөвшөөрөл олгосноор 2020 оны 2 дугаар улирлын байдлаар 103 ҮХЭХЗ-ын компани тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байна.



ҮХЭХЗ-ЫН КОМПАНИЙН ТОО

Нийт ҮХЭХЗ-ын үйл ажиллагаа явуулдаг компаниудын 1.7 хувь нь тусгай зөвшөөрөл авчээ.

УБЕГ-т бүртгэлтэй

6000

Хорооны тусгай зөвшөөрөлтэй

103

Тусгай зөвшөөрөлтэй ҮХЭХЗ-ын компаниудын:

Брокер
130Агент
784

Нэг ҮХЭХЗ-ын компани дунджаар 1 брокер, 7 агенттай ажиллаж байна.



НИЙТ ХӨРӨНГӨ

Тусгай зөвшөөрөлтэй ҮХЭХЗ-ын компаниудын нийт хөрөнгө 10.6 тэрбум төгрөг, тусгай зөвшөөрлийн хүрээнд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 15 сая төгрөг байхаар тогтоосноор нийт дүн нь 1.9 тэрбум төгрөг байна.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ҮХЭХЗ-ЫН КОМПАНИУДЫН БАЙРШИЛ



СҮХБААТАР **31**

ХАН-УУЛ **24**

ЧИНГЭЛТЭЙ **20**

БАЯНГОЛ **9**

БАЯНЗҮРХ **17**

Орхон аймаг **1**

Дархан-Уул аймаг **1**



БАЙРШИЛ

Нийт тусгай зөвшөөрөлтэй ҮХЭХЗ-ын компаниудын 30.1 хувь нь Сүхбаатар дүүрэгт, 23.3 хувь нь Хан-Уул дүүрэгт, 19.5 хувь нь Чингэлтэй, 16.5 хувь нь Баянзүрх дүүрэгт, 8.7 хувь нь Баянгол дүүрэгт тус тус байршилтай бол хөдөө, орон нутагт зөвхөн 2 буюу нийт ҮХЭХЗ-ын компаниудын 1.9 хувь нь хувь нь үйл ажиллагаа эрхэлж байна.

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН КОМПАНИУДЫН ТОО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР /ДАВХАРДСАН ТООГООР/



ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН МЕНЕЖМЕНТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ


2020 оны 6 дугаар сард 1 ҮХЭХЗ–ын компаниар дамжуулан 2 харилцагч 15.4 сая төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгөд менежментийн үйлчилгээ үзүүлэн тус бүр 5 хувийн шимтгэлийг төвлөрүүлжээ.

**ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ,
ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ**


2020 оны 6 дугаар сард 37 ҮХЭХЗ–ын компаниар дамжуулан 399 хэлцлээр нийт 296.6 мянган м.кв талбай, 49.2 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг зуучлуулан худалдан, худалдан авч шилжүүлжээ.

Чингэлтэй дүүрэгт 1 м.кв байрны үнэ 3,576.9 мянган төгрөг буюу хамгийн өндөр үнэтэй, харин Сонгинохайрхан дүүрэгт 1 м.кв байрны үнэ хамгийн хямд буюу 1,610.9 мянган төгрөгний үнэтэйгээр борлуулагдсан байна.

Шимтгэлийн хэмжээ /ҮХЭХЗ–ын компанийн тоогоор/



Шимтгэлийн хэмжээ /ҮХЭХЗ–ын компанийн тоогоор/



Түрээсийн шимтгэл сарын түрээсийн дүнд нэг удаа суутгагдсан болно.

**ТҮРЭЭСЛЭХ, ТҮРЭЭСЛҮҮЛЭХ
ҮЙЛЧИЛГЭЭ**

2020 оны 6 дугаар сард 25 ҮХЭХЗ–ын компаниар дамжуулан 185 хэлцэл нийт 16.1 мянган м.кв талбай, 32 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг түрээслүүлжээ.

Нийт харилцагчийн 73.5 хувь буюу 136 нь түрээслэх, 26.5 хувь буюу 49 нь түрээслүүлэх гэрээ байгуулсан байна.

ҮХЭХЗ–ЫН ҮЙЛЧИЛГЭЭ /БАЙРШЛААР/



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллага /ФАТФ/-ын 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтад орсон тул дээрх чиглэлийн бодлого стратеги, зохицуулалтыг сайжруулах зорилтын хүрээнд УИХ-аас 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулснаар санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч болох үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамааруулж зохицуулах, хяналт тавих үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэхээр хуульчлагдсан.
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагын дагуу үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэх байгууллагын хүний нөөц, ажлын байр, тоног төхөөрөмж, санхүүгийн чадамж болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах зарчим, нөхцөл шаардлагыг тухайн салбарт оролцогчдын онцлогт нийцүүлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ыг батлан 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн тусгай зөвшөөрөл олгож эхлээд байна.
- Тусгай зөвшөөрөл олгосон ҮХЭХЗ-ын компаниудад хяналт шалгалт хийх “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам” –ыг Хорооны 2020 оны 181 дүгээр тогтоолоор батлаад байна. Уг журмын хүрээнд 2020 оны 6 дугаар сараас эхлэн ҮХЭХЗ-ын компаниудаас сар, улирал, хагас жил болон жилээр мэдээ, мэдээлэл авч эхлэн зайны хяналтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа.



ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН САЛБАР

Арилжаа эрхлэгчдийн тоо

275



Салбарын төлөв

Худалдаж, худалдан
авсан үнэт металл

235.7

тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Нийт ахиуц ашиг

32%

Бодлого зохицуулалт



САЛБАРЫН ТӨЛӨВ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Хорооноос 2020 оны 5 дугаар сарын 06-ны өдрөөс үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож эхэлснээр 2020 оны 2 дугаар улиралд 8 хуулийн этгээд, 267 иргэн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулдаг боллоо.

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ
ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН
АРИЛЖАА ЭРХЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД

8



43

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ
ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН
АРИЛЖАА ЭРХЛЭГЧ

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА
ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ
ИРГЭД

71



153


ҮНЭТ МЕТАЛЛ БОЛОН ҮНЭТ ЧУЛУУГААР
ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ
ИРГЭД

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БҮСҮҮД



Үнэт металл, үнэт чулуу эсхүл тэдгээрээр хийсэн арилжаа эрхлэгчдийн 96.9 хувь Улаанбаатар хотод, үлдсэн 3.1 хувт нь хөдөө, орон нутагт тархжээ.

ҮНЭТ МЕТАЛЛ БОЛОН ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ /БАЙРШЛААР/



Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид ихэвчлэн хөдөө, орон нутагт, харин тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид голчлон Улаанбаатар хотод байршсан байна. Тухайлбал үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн 56 хувь нь хөдөө, орон нутагт, 44 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч

**ӨМНӨГОВЬ 2
ДАРХАН-УУЛ 1**

Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч

**ХОВД 2
ДАРХАН-УУЛ 1**

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч

**БАЯНХОНГОР 13
СЭЛЭНГЭ 12
ТӨВ 6
ДАРХАН-УУЛ 3
ӨМНӨГОВЬ 2
УВС 2
ДОРНОГОВЬ 1
ӨВӨРХАНГАЙ 1**

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

2020 оны 6 дугаар сард 882.9 кг, 125.4 тэрбум төгрөгийн үнэт металлыг худалдаж, 860.5 кг, 109.8 тэрбум төгрөгийн үнэт металлыг худалдан авчээ.



АЛТНЫ ХУДАЛДАН АВАЛТ /БАЙРШЛААР/

ТӨВ
АЙМАГ

70.1%

ДАРХАН-УУЛ
АЙМАГ

8.1%

БУЛГАН
АЙМАГ

7.7%

БАЯНХОНГОР
АЙМАГ

5.4%

СЭЛЭНГЭ
АЙМАГ

4.1%

ӨВӨРХАНГАЙ
АЙМАГ

2.7%


ХОВД
АЙМАГ

1.8%

АШИГТ АЖИЛЛАГАА

НИЙТ ХӨРӨНГӨ БА ЦЭВЭР АШИГ

2020 оны 2 дугаар улиралд үнэт металл, үнэт чулуу, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 8 компанийн нийт хөрөнгө 8.1 тэрбум төгрөг ба тайлант хугацаанд 1.3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж, хуримтлагдсан ашгийн дүнг бууруулжээ.



ХҮСНЭГТ 3. ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ КОМПАНИУДЫН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /ХУВИАР/

ҮЗҮҮЛЭЛТ	Хувиар
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7.4%
Дансны авлага	20.5%
Бусад авлага	7.7%
Бусад санхүүгийн хөрөнгө	1.0%
Бараа материал	13.8%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1.0%
Эргэлтийн хөрөнгийн дүн	51.4%
Үндсэн хөрөнгө	48.0%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.6%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	48.6%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	100.0%
Дансны өглөг	38.4%
Цалингийн өглөг	0.1%
Татварын өр	3.6%
НДШ – ийн өглөг	0.2%

ҮЗҮҮЛЭЛТ	Хувиар
Банкны богино хугацаат зээл	43.1%
Хүүний өглөг	9.7%
Бусад богино хугацаат өр төлбөр	11.8%
Богино хугацаат өр төлбөрийн дүн	106.9%
Урт хугацаат зээл	4.3%
Урт хугацаат өр төлбөрийн дүн	4.3%
Өр төлбөрийн нийт дүн	111.3%
Өмч	42.9%
– хувийн	42.9%
Эздийн өмчийн бусад хэсэг	4.7%
Хуримтлагдсан ашиг	-58.9%
Эздийн өмчийн дүн	-11.3%
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	100.0%

ХҮСНЭГТ 4. ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ КОМПАНИУДЫН ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /ХУВИАР/

Үзүүлэлт	Хувь
Нийт орлого	100.0%
Борлуулалтын орлого (цэвэр)	75.0%
Түрээсийн орлого	20.5%
Хүүний орлого	3.3%
Бусад орлого	1.1%

Үзүүлэлт	Хувь
Нийт зардал	100.0%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	10.9%
Борлуулалт, маркетингийн зардал	46.5%
Ерөнхий ба удирдлагын зардал	39.1%
Санхүүгийн зардал	1.5%
Бусад зардал	1.4%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.5%

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- УИХ-ын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулж, хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д “үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа”-г санхүүгийн үйлчилгээнд хамааруулахаар хуульчилсан бөгөөд мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т “Энэ хуулийн 3.1-т заасан санхүүгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Хороо олгоно” гэж заасан.
- Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулснаар үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамааруулсан бөгөөд зохицуулах, хяналт тавих үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэхээр хуульчлагдсан.
- Дээрх хуульд заасан зохицуулалтын дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 150 дугаар тогтоолоор “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ыг баталсан. Журам батлагдсанаар Хорооноос 2020 оны 5 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, хуулийн этгээдүүдэд тусгай зөвшөөрөл олгож эхэлсэн.
- Тусгай зөвшөөрөл олгосон иргэд, хуулийн этгээдүүдэд “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ыг Хорооны 2020 оны 182 дугаар тогтоолоор баталснаар 6 дугаар сараас эхлэн сар, улирал, хагас жил болон жилээр санхүүгийн тайлан, бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээлэл зэргийг Фина системээр хүлээн авч зайны хяналтыг хэрэгжүүллээ.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2018.ИИ	2019.ИИ	2020.ИИ
Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/	2484.9	2,604.8	2,503.7
ЗЗҮ/ДНБ	8.9%	8.1%	6.8%
Хөрвөх чадвар	2.0%	3.2%	0.9%
Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/	49.8	82.5	23.5
Компанийн өрийн хэрэгслийн арилжаа /тэрбум төгрөг/	0.6	0.1	5.0
ЗГҮЦ–ны арилжаа /тэрбум төгрөг/	27.6	7.9	0.6
ТОП–20 индекс	19,961.46	20,785.21	16,208.94
MSE А индекс	9,823.9	9743.03	8062.47
MSE Б индекс	9633.86	8116.71	7480.85
ХК–ийн тоо	303	307	304
ҮЦК–ийн тоо	54	52	53
ХАА–н биржийн арилжааны дүн /тэрбум төгрөг/	443.5	523.0	162.1
МАРІХ	835,422.7	864,004.5	918,691.4

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2018.ИИ	2019.ИИ	2020.ИИ
Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/	282.2	354.7	359.2
Даатгалын болон давхар даатгалын нийт хураамж /тэрбум төгрөг/	84.1	104.0	96.4
Нийт нөхөн төлбөр /тэрбум төгрөг/	29.2	25.7	27.7
Нөөц сан /тэрбум төгрөг/	135.5	158.9	159.7
Давхар даатгалын хураамж /тэрбум төгрөг/	23.7	33.7	24.8
Цэвэр ашиг /тэрбум төгрөг/	6.3	12.6	11.7
Мэргэжлийн оролцогчид	2018.ИИ	2019.ИИ	2020.ИИ
Ердийн даатгал	15	15	15
Урт хугацааны даатгал	1	1	1
Давхар даатгал	2	2	1
Даатгалын төлөөлөгч	2587	2493	2453
Даатгалын зуучлагч	46	52	55
Хохирол үнэлэгч	28	26	26
Актуарч	25	30	32
Аудитор	131	144	144
Аудиторын компани	43	44	45

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

/Тэр бум төгрөг/

Үзүүлэлтүүд	2018.И	2019.И	2020.И
Нийт хөрөнгө	1,143.7	1,533.1	1,862.2
Эргэлтийн хөрөнгө	1,101.0	1,477.9	1,791.4
Мөнгөн хөрөнгө	277.1	318.8	395.3
Богино хугацаат хөрөнгө оруулалт	2.1	2.4	10.3
Нийт зээл	768.3	1,096.7	1,307.3
Хэвийн зээл	653.8	956.5	1,131.1
Хугацаа хэтэрсэн зээл	34.4	42.9	62.3
Чанаргүй зээл	80.2	97.4	113.9
Зээлийн эрсдэлийн сан	57.8	72.2	88.8
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	9.8	10.3	12.9
Эргэлтийн бус хөрөнгө	42.6	55.2	70.7
Нийт өр төлбөр	255.2	378.0	524.5
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	45.6	84.1	118.6
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	133.7	167.3	212.3
Төслийн зээлийн санхүүжилт	16.6	17.8	23.4
Эзэмшигчдийн өмч	888.5	1,155.2	1,337.7
Хоёрдогч өглөг	1.0	0.8	0.8
Хувьцаат капитал	707.8	892.2	977.3
Хуримтлагдсан ашиг	170.9	230.1	325.9
ББСБ-ын тоо	539.0	538.0	542.0
Үүнээс: УБ хот	464.0	463.0	465.0
Хөдөө, орон нутаг	75.0	75.0	77.0
Харилцагчдын тоо	1,423,597.0	2,348,014.0	2,766,913.0
Нийт орлого	118.4	158.3	200.2
Хүүгийн орлого	99.2	132.9	163.7
Хүүгийн бус орлого	14.0	22.4	32.5
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	5.3	3.0	4.0
Нийт зардал	72.0	94.0	123.6
Хүүгийн зардал	9.2	15.1	22.3
Хүүгийн бус зардал	44.1	53.3	70.6
Болзошгүй эрсдэлийн зардал	11.4	16.2	21.0
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	1.5	1.5	1.7
Цэвэр ашиг	46.5	64.3	76.6

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТООН МЭДЭЭЛЭЛ

/Тэр бум төгрөг/

Үзүүлэлтүүд	2018.И	2019.И	2020.И
Нийт хөрөнгө	176.1	210.6	234.4
Эргэлтийн хөрөнгө	172.1	205.8	230.2
Мөнгөн хөрөнгө	32.9	45.4	59.5
Авлага	6.4	6.8	8.1
Эргэлтийн бус хөрөнгө	3.9	4.8	4.2
Үндсэн хөрөнгө /цэврээр/	3.9	4.7	4.0
Биет бус хөрөнгө	0.0	0.1	0.2
Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн бус хөрөнгө	0.0	0.0	0.0
Нийт зээл	134.1	156.5	165.1
Хэвийн зээл	121.7	145.3	152.8
Хугацаа хэтэрсэн зээл	4.1	4.9	5.1
Чанаргүй зээл	8.3	6.4	7.1
Өр төлбөр	147.4	174.3	188.9
Хадгаламж	124.5	148.4	163.4
Богино хугацаат зээл	5.3	6.1	2.7
Урт хугацаат өр төлбөр	9.3	6.5	7.1
Бусад богино хугацаат өр төлбөр	8.3	13.4	15.7
Өөрийн хөрөнгө	28.7	36.3	45.5
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	14.6	17.5	18.2
Хоршоологчдын өмч	13.9	18.6	27.1
Хуримтлагдсан орлого /алдагдал/	6.1	9.5	15.1
Нийт орлого	19.3	24.4	26.7
Хүүгийн орлого	18.5	23.4	25.7
Үйл ажиллагааны бусад орлого	0.4	0.5	0.5
Үйл ажиллагааны бус орлого	0.4	0.5	0.6
Нийт зарлага	18.2	21.5	21.6
Хүүгийн зардал	10.8	13.7	14.2
Болзошгүй эрсдэлийн сангийн зардал	2.2	1.5	0.8
Үйл ажиллагааны зардал	4.8	5.8	6.0
Үйл ажиллагааны бус зардал	0.2	0.2	0.2
Цэвэр орлого	1.1	2.9	5.2
ХЗХ–дын тоо	289	275	256
УБ ХЗХ–дын тоо	186	174	155
Орон нутаг ХЗХ–дын тоо	103	101	101
Гишүүдийн тоо /мянга/	61.2	67.4	72.2



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia